



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn


2023.06.19 № 227

танай _____-ны № _____-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг, судалгаа, аудитын илрүүлэлтийн матриц, алдаа зөрчлийн бүртгэлийн хамт хүргүүллээ.

Хавсралт 32 хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА





НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
АУДИТЫН КОД: АРА-2023/30-1-ШТА-НА

ЦЭЦЭРЛЭГХОТ
2023 ОН



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatar@audit.gov.mn

Багийн ахлагч: Ахлах аудитор. П.Цэцэгдулам

Утас: 9933-9725 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 9921-0906 Цахим хаяг: Tsog-erdeneg@audit.gov.mn

Аудитор: Л.Соёлмөнх

Утас: 9905-1581 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn

Аудитор: Н.Энхчимэг

Утас: 8989-1150 Цахим хаяг: enkhchimegn@audit.gov.mn

Аудитор: А.Пүрэвцэцэг

Утас: 9974-6363 Цахим хаяг: purevtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2 4-6
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор П.Цэцэгдулам Аудитор Л.Соёлмөнх Н.Энхчимэг Г.Цог-Эрдэнэ А.Пүрэвцэцэг 2023 оны 06 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ЗАРИМ ЗААЛТУУД ХООРОНДОО УЯЛДААГҮЙ БАЙНА А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэн, үр дүнг үнэлж байна А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэжээ БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 83.7 ХУВИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА Б1. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа Засгийн газрын холбогдох журмын дагуу хэрэгжиж байна Б2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 28.7 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна БҮЛЭГ В. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ, НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭГ АВААГҮЙ БАЙНА В.1.Төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, цахим бүртгэлийн системийн хуулийн хэрэгжилт 22.0 хувьтай байна В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээг хийгээгүй байна Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал Хүснэгтийн товьёг Графикийн товьёг	7 7 8 10 12 15 16 20 23 31 32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Аймгийн хэмжээний 19 сумдын Засаг дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн байдал	13
2	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалттай холбоотой 2021 онд 309.1 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалт	24
3	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалттай холбоотой /2022 он/	25
4	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалттай холбоотой /2023 он/	25
5		

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Гэрээний хэрэгжилтийн байдал	12
2	Аймаг, сумдын 2021-2023 оны байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг хуулийн хэрэгжилтийн хувиар харуулбал:	23

Хүснэгтийн товч

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Аймаг болон сумдын төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний батлагдсан зардлын дүн болон хэрэгжилтийн байдал 2021-2022 оноор	5
2	2022 онд Хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн байдал	6
3	Монгол Улсын Их хурлын тогтоолоор хүчингүй болгосон бодлогын баримт бичгүүд	9
4	Менежмент төлөвлөгөө батлагдсан огноо болон хэрэгжилтийг дэлгэрэнгүй	9
5	Аймгийн хэмжээний ойн нөхөрлөлийг сумдаар ангилсан байдал	10
6	Гэрээний хэрэгжилтийн байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн байдал	11
7	БОАЖГ-ын гэрээний хэрэгжилт	13
8	Ойн ангиудын гэрээний хэрэгжилт	14
9	Байгалийн нөөц ашиглах дээд хэмжээний судалгаа	15
10	Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа	16
11	Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийн судалгаа	17
12	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	18
13	БОХНСАХ нь менежмент төлөвлөгөөтэй уялдсан байдал	20
14	Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан БОХНСАХ-ний зардлын дэлгэрэнгүй	20
15	БНАТ-ийн орлогын төлөвлөлт /2021 он/	21
16	БНАТ-ийн орлогын төлөвлөлт /2022 он/	21
17	БНАТ-ийн орлогын төлөвлөлт /2023 он/	22
18	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2021, 2022 оны төлөвлөлт, гүйцэтгэл	24
19		25
20		

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ:

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орхон Чулуут голын сав газрын захиргаа, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Цэцэгдулам, аудитор Г.Цог-Эрдэнэ, Л.Соёлмөнх, А.Пүрэвцэцэг, Н.Энхчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023.05.12-2023.06.19-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдсан бөгөөд төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөгдөх хөнгөлөх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хүрээнд 5 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6.2-т “Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ” гэсэн зорилтын дагуу Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021, 2022 онуудын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 5 дэд зорилтыг тусган хэрэгжүүлжээ.

Архангай аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 2021 онд 775.7 сая төгрөгөөр 39 арга хэмжээг, 2022 онд 1,166.3 сая төгрөгөөр 48 арга хэмжээнд зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 2021 онд 498.8 сая төгрөгөөр 38, арга хэмжээг, 2022 онд 1,149.7 сая төгрөгөөр 45 арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Хүснэгт 1. Аймаг болон сумдын төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний батлагдсан зардлын дүн болон хэрэгжилтийн байдал 2021-2022 оноор

/сая төгрөг/

№	Сумын нэр	Огноо	Батлагдсан		Хэрэгжүүлсэн	
			Арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	БОАЖГ	2021	17	339.5	16	192.5
		2022	18	574.7	18	486.7
2	Цэнхэр	2021	12	90.5	12	80.6
		2022	6	238.0	5	190.1
3	Жаргалант	2021	1	105.2	1	23.5
		2022	-	-	-	-
4	Булган	2021	7	52.2	7	48.4
		2022	15	226.0	15	226.0
5	Ихтамир	2021	2	188.3	2	153.9
		2022	1	26.1	1	162.6
6	Цахир	2021				
		2022	8	101.5	6	84.3
Нийт дүн		2021	39	775.7	38	498.8
		2022	48	1,166.3	45	1,149.7

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/372 дугаар тушаалаар ойгоос хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх дээд хэмжээг аймгийн 5 сумын хэмжээнд 1,129.200 кг

байхаар баталжээ. Гүйцэтгэлээр 1,212.465 кг самар бэлтгэж 1,697.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. 2022 онд Хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн байдал

№	Сумын нэр	БОАЖСайдын 2022.09.09-ны а/372 дугаар тушаал		Гүйцэтгэл		/сая төгрөг/ Нөөцийн дээд хэмжээнээс хэтэрсэн самар	
						Бэлтгэсэн кг	мөнгөн дүн
1	Цэнхэр	бэлтгэх дээд хэмжээ кг	Төвлөрүүлбэл зохих мөнгөн дүн	Бэлтгэсэн кг	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	34,156	47.8
2	Булган	196,560	275.2	230,716	323.0		
3	Жаргалант	198,640	278.1	188,046	263.2		-
4	Ихтамир	277,360	388.3	279,304	391.0	1,944	2.7
5	Тариат	239,200	334.8	239,000	334.6		-
		217,440	304.4	275,400	385.6	57,960	81.1
	Дүн	1,129,200	1,580.8	1,212,465	1,697.4	94,059	131.6

ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Аудитын явцад шалгагдагч байгууллагуудын төрийн албан хаагч, мэргэжилтнүүд олон солигдсон, тогтвор суурьшилгүй, зарим суманд холбогдох мэргэжилтэн байхгүйгээс модны эрхийн бичиг, хоорондын тооцоо нийлсэн акт болон бусад шаардлагатай баримт материалуудыг бүрэн ирүүлдэггүй, мөн аудитын явцад хийгдсэн судалгаа хэт нүсэр, хугацаа давчуу, судалгааны нэгтгэл хийж байх явцад хүснэгт 3-н удаа өөрчлөгдсөн нь тоон мэдээллийг дахин давтан хийхэд хүргэсэн зэрэг хүндрэл бэрхшээлүүд гарч байлаа.

БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ЗАРИМ ЗААЛТУУД ХООРОНДОО УЯЛДААГҮЙ БАЙНА

А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэн, үр дүнг үнэлж байна

А1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим заалт нь бусад хууль тогтоомж, журмын холбогдох заалттай нийцэхгүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акттай нийцэж байгаа эсэхэд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Орхон, чулуут голын сав газрын захиргааны холбогдох албан тушаалтнууд болон 19 сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг хамруулан нийт 25 албан хаагчдаас цахимаар санал асуулга авч нэгтгэхэд дараах хууль, тогтоомж, журмын зарим заалт нь хоорондоо зөрчилдөж байгаа саналыг ирүүлсэн. Үүнд:

- ✓ Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1¹ дэх заалт “ батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад **жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх**” гэсэн заалт нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1², МУЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ын 2.5³ заалттай зөрчилдөж байна.
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1⁴ “ ¹ Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд доод дээд төлбөрийн хязгаарыг тогтоосон” заалт нь тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1⁵ “хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах зориулалтаар ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх гэсэн заалтууд хоорондоо нийцэхгүй байна.

Иймд аудитаас Төсвийн тухай хууль болон МУЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ын холбогдох

¹ батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх

² төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх

³ Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ

⁴ Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд доод дээд төлбөрийн хязгаарыг тогтоосон

⁵ "хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах зориулалтаар ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх

заалтын хүрээнд Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг уламжиллаа.

A1.2. *Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилт, арга хэмжээг дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусган, хэрэгжилтийг тооцож ажилласан байна.*

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 6.2-т "Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ" гэж тусгасан. Зорилтын хүрээнд 1-р үе шат буюу 2021-2030 онд "Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе"-ийг хэрэгжүүлэх буюу "Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэг, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана" гэжээ.

Энэ хүрээнд Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021, 2022 онуудын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Ойн нөхөн сэргээлтийг сайжруулж, нутгийн модны үр бэлтгэх, мод үржүүлгийн плантаци байгуулан, ойжуулах, ойн цэвэрлэгээ, ойн хөнөөлт шавж өвчний судалгаа тэмцлийн ажлын хүрээнд 2021-2022 онд 7 суманд 65 га мод үржүүлгийн талбайд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэхээр хүлэмж болон ил талбайд навчит, шилмүүст модны 50 кг үр, 300.0 мянга гаруй мөчрөөр тарилт хийж усалгаа, арчилгааны ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгэжээ.
- ✓ Ойн ангиуд, ойн мэргэжлийн байгууллага, иргэд, иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд 2022 онд сум дундын ойн ангиудтай хамтран "Нэг байгаль хамгаалагч-50 кг шинэсний боргоцой" түүх аяныг өрнүүлж аймгийн хэмжээнд 60 кг шинэсний цэвэр үрийг түүж, 2023 оны хавар мод үржүүлгийн газарт тарих нөөцийг бий болгосон байна.
- ✓ Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг баримтлан төсөвлөсөн байна.
- ✓ Биологийн олон янз байдлыг хангахад чиглэсэн байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээх ажлын хүрээнд 2022 онд мод үржүүлгийн талбайд 1 настай 10 гаруй төрөл зүйлийн 629.0 мянган ширхэг тарьц суулгацыг бүрдүүлж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 4 суманд 3 га талбайд шинээр мод үржүүлгийн талбайг байгуулжээ.
- ✓ 2022 онд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд "Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээг зохион байгуулсан байна. Мөн 1,5 га-д техникийн нөхөн сэргээлт, 26 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэжээ.

Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо, хэрэгжилтийг орон нутгийн түвшинд ханган ажиллаж байгааг аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 2021 онд 90 хувь, 2022 онд 95 хувь дунджаар 92.5 хувьтай үнэлжээ.

A1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд ойн болон усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Ойн менежмент төлөвлөгөөний талаар:

Аймгийн ойн болон усны нөөцийн менежмент төлөвлөгөөг боловсруулж холбогдох дээд шатны байгууллагаар батлуулаагүй, менежмент төлөвлөгөөгүй байна.

Энэ нь Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.9 дэхь заалттай нийцэхгүй байгаа тул Ойн тухай хуулийн дагуу аймгийн хэмжээний ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

Харин аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад ойн сан бүхий 16 сум 2022-2026 онд хэрэгжих ойн менежмент төлөвлөгөөг батлуулсан байна.

Хүснэгт 4. Менежмент төлөвлөгөө батлагдсан огноо болон хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

№	Менежментийн төлөвлөгөө	баталсан шийдвэрийн огноо, дугаар	Хэрэгжих хугацаа	2021-2023 оны байдлаар
1	Улсын ойн менежментийн төлөвлөгөө	МУЗГ-ын 2011.12.21 362	2011-2015 онд хэрэгжиж дууссан.	Менежмент төлөвлөгөө батлагдаагүй
2	Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө	БОАЖЯ 2011 он	2011-2015 онд хэрэгжиж дууссан.	Менежмент төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй.
3	Ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөө	Аймгийн Засаг дарга	2022-2026 он	Аймгийн хэмжээнд ойн сантай 16 сум ойн менежмент төлөвлөгөөгөө батлуулжээ.
4	Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	МУЗГ-ын 2013.11.30 №389	2012-2021 онд хэрэгжиж дууссан.	Менежмент төлөвлөгөө батлагдаагүй
5	Улсын усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө /цаашид "сав газрын менежментийн төлөвлөгөө" гэх/	БОАЖС-ын 2020.01.24 А/42	2020-2024 он	Аймгийн хэмжээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2021 онд 4, 2022 онд 3 арга хэмжээг хэрэгжүүлж 64.2 хувьтай тайлагнасан.
6	Агнуурын нөөц бүхий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө	БОАЖЯ 2019	2019-2023	Аймгийн хэмжээнд ангийн менежмент төлөвлөгөөнд тусгагдсан 12 зорилтын 43 арга хэмжээний хэрэгжилтийг 2021, 2022 оны байдлаар хэрэгжилтийг тооцож тайлагнаагүй.

2023 оны эхний 6-н сарын байдлаар аймгийн 260,663 га ойн санг гэрээгээр эзэмшигч 15 сумын 101 нөхөрлөл, аж ахуйн нэгжээс 3 сумын 5 нөхөрлөл нь ойн менежмент төлөвлөгөөг батлуулсан байна.

Хүснэгт 5. Аймгийн хэмжээний ойн нөхөрлөлийг сумдаар ангилж харуулбал

№	Сумын нэр	Нөхөрлөлийн тоо	Эзэмшиж байгаа ойн талбай /га/	Ойн менежмент төлөвлөгөө батлуулсан байдал
1	Цэнхэр	12	26,260	
2	Төвшрүүлэх	8	4,442	
3	Булган	12	47,929	
4	Хотонт	14	18,958	
5	Эрдэнэмандал	9	30,838	2 нөхөрлөл ойн менежмент төлөвлөгөөг батлуулсан.
6	Цэцэрлэг	5	8,214	
7	Батцэнгэл	2	12,378	2 нөхөрлөл ойн менежмент төлөвлөгөөг батлуулсан.
8	Жаргалант	3	2,035	
9	Хайрхан	3	2,302	1 нөхөрлөл ойн менежмент төлөвлөгөөг батлуулсан.
10	Ихтамир	22	39,702	
11	Чулуут	1	3,000	
12	Тариат	4	9,100	
13	Цахир	1	8,500	
14	Өндөр-Улаан	3	27,340	
15	Хангай	2	19,665	
Нийт		101	260,663	

Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжээс 96 нөхөрлөл, аж ахуйн нэгж нь ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй нь Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.8.3 дахь заалтыг зөрчиж байх тул аудитаас ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх зорилготой нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийн менежмент төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилт, үр дүн тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн БОАЖГ-т хүргүүлээ.

Ангийн менежмент төлөвлөгөөний талаар: Ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ангийн менежмент төлөвлөгөөг 2019 онд БОАЖА-аар батлуулжээ. Аймгийн ангийн менежмент төлөвлөгөөний хугацаа 2023 онд хэрэгжиж дуусах ба цаашид ан, агнуурын нөөцийн хэмжээг тогтоосон менежмент төлөвлөгөө боловсруулах шаардлагатай болсон байна.

Ангийн менежмент төлөвлөгөөнд тусгагдсан 12 зорилтын 43 арга хэмжээний хэрэгжилтийг 2021-2022 онуудад тайлагнаагүй нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2, 5.8.3 дахь заалтыг зөрчсөн байх тул аудитаас амьтны тухай хуулийн дагуу ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ангийн менежмент төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнаж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлээ.

A2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэжээ

A2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 2021 онд 9 зорилтын 49 арга хэмжээг, 2022 онд 9 зорилтын 52

арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталжээ. Үүнээс 2021 онд 21, 2022 онд 19 арга хэмжээ нь байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгажээ.

Аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаас үзэхэд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний хэрэгжилт дундажаар 2021 онд 89 хувь, 2022 онд 86.8 хувьтай үнэлэгджээ.

Хүснэгт 6. Гэрээний хэрэгжилтийн байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн байдал

№	Хэрэгжилт ийн он	Зорилт ын тоо	Нийт арга хэмжээ	БНАТ түүнтэй холбоотой арга хэмжээ	Биелэлтийн үнэлгээ					Биелэлти йн дундаж хувь
					100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	
1	2021	9	49	21	2	17	2			89
2	2022	9	52	19	14		1	3	1	86.8

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдаас аймгийн Орхон, Чулуут голын сав газартай байгуулсан гэрээгээр 2021 онд 32 арга хэмжээг, 2022 онд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга хэмжээний дундаж хэрэгжилт 2021 онд 80.9 хувь, 2022 онд 92.3 хувьтай үнэлжээ.

A2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.


Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 71.7 хувь гэж үнэлжээ.

Гэрээ дүгнэсэн баримтыг архивын нэгж үүсгэдэггүй шалтгаанаас аудитын хяналтаар 8 сумын баримт шалгагдсан. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан" 7 арга хэмжээний хэрэгжилтийг дунджаар 63.93 хувьтай дүгнэжээ. *Тухайлбал:* Ойн нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой 2 арга хэмжээ, ан амьтантай холбоотой 1 арга хэмжээ, байгалийн нөөцийн баялаг ашиглаж буй иргэн, ААН-н үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчил арилгуулах 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.

Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дунджаар 128 арга хэмжээний хэрэгжилтийг 76.5 хувьтай дүгнэснээс "Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан" 13 арга хэмжээний хэрэгжилтийг 73.2 хувьтай үнэлжээ. *Тухайлбал:* Рашаантай холбоотой 3 арга

хэмжээ, Ой, модтой холбоотой 8 арга хэмжээ, нутгийн иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулах замаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг байгуулахтай холбоотой 1 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.

Дүрслэл-1. Аймгийн хэмжээний 19 сумдын Засаг дарга нартай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн байдал



Аймгийн засаг дарга БОАЖГ-тай хийсэн 2021, 2022 оны гэрээний биелэлтийг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2021 оны 12 арга хэмжээг 92.5 хувиар, 2022 оны 16 арга хэмжээний хэрэгжилтийг 95 хувиар үнэлжээ.

Хүснэгт -7. БОАЖГ-ын гэрээний хэрэгжилт

№	Нэр	Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагч нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний							
		2021 он				2022 он			
		Дундаж үнэлгээ / Нийт арга хэмжээ/		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
		/тоо/	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	63	79.5	12	92.5	71	86.9	16	95

Сум дундын ойн анги нь 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр БОАЖГ-тай хийсэн 2022 оны гэрээний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дүгнэснийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-8. Ойн ангиудын гэрээний хэрэгжилт

Нэр	Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар харьяа ойн ангийн захирагч нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний							
	2021 он				2022 он			
	Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Цэнхэр сум дахь сум дундын ойн анги	Гэрээ байгуулаагүй				27	85.7	12	88.3
Эрдэнэмандал сум дахь сум дундын ойн анги					30	93	13	92.3
Ихтамир сум дахь сум дундын ойн анги					28	80	10	76

Хүснэгтээс харахад 2022 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд БНАТ-ийн хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 сумын сум дундын ойн анги 35 арга хэмжээг тусгаж дунджаар 85.5 хувьтай үнэлсэн байна.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН 83.7 ХУВИЙГ ХУУЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

Б1. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа Засгийн газрын холбогдох журмын дагуу хэрэгжиж байна

Б1.1 Аймгийн ИТХ-аар ан, амьтны нөөц ашиглах тоо хэмжээг сум тус бүрээр батлахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2021-2023 онд ангийн нөөцийн дээд хэмжээг 9 зүйл, төрөл дээр тогтоосон бол ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг 3 зүйлээр, ойн дагалдах баялгийг 1 зүйлээр тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-9. Байгалийн нөөц ашиглах ашиглах дээд хэмжээний судалгаа

Нэр	Огноо	Ан амьтан				Ой						
		Агнуулах, барих зориулалтаар			Модны төрөл	Хэрэглээний мод, түлээний зориулалт		Ойн дагалт баялгийн төрөл зүйл	Ойн дагалт баялаг			
		Ашиглах дээд хэмжээ тогтоосон зүйлийн тоо				Ашиглах дээд хэмжээ тогтоосон зүйлийн тоо			Ашиглах дээд хэмжээ тогтоосон зүйлийн тоо			
		Нийт	үүнээс нөөц тогтоосноос			Нийт	үүнээс нөөц тогтоосноос		Нийт	үүнээс нөөц тогтоосноос		
Архангай	2021	9	6	6	3	3	3	1	1	1		
	2022	9	6	6	3	3	3	1	1	1		
	2023	9	3	3	3	3	3	1	1	1		

Ан амьтан агнуулах, барих ашиглах дээд хэмжээний тухайд : Тайлангийн жилд ахуйн зориулалтаар агнах амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг БОАЖС-ын тушаалаар батлан ирүүлж байгаа хэдий ч тухайн шийдвэр орон нутгийн төсөв батлагдснаас хойш ирдэг тул аймгаас явуулсан дээд хэмжээний саналтай зөрөх тохиолдол

гардаг байна.

Аймгийн ИТХ-аар ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг батлахдаа зөвхөн төвлөрүүлэх мөнгөн дүнг сум тус бүрээр баталж, тоо хэмжээг батлахгүй байгаа нь Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2⁶, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 2.4⁷ дэх заалтуудтай бүрэн нийцэхгүй байна. / Энэ талаарх саналыг тайангийн бүлэг А1.1-д уламжлах саналаар тусгасан болно./

Аудитаас төсөв батлахдаа ахуйн зориулалтаар агнах амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр батлан Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 2.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлээ.

Ойн дагалт баялагийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж ашиглах талаар:

2022 онд Ойн дагалт баялагийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж ашиглах үүднээс 5 сумын хэмжээнд 1,2 сая кг самар бэлтгэж орон нутгийн төсөвт 1,697.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

БОАЖС-дын 2022 оны А/372 дугаар тушаалаар аймгийн хэмжээнд 5 суманд ойн дагалт баялагийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж ашиглах дээд хэмжээг 1,129,200 кг-аар тогтоосон. Аудитаар 3 сум дээд хэмжээг 94,059 кг-аар хэтрүүлэн үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэсэн нь БОАЖС-дын 2022 оны А/372 дугаар “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” тушаалыг зөрчиж байна.

Аудитаас Байгаль орчин аялал, жуулчлалын Сайдын тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлээ.

Б1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа Засгийн газрын холбогдох журмын дагуу хэрэгжиж байна.

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа нь 2021-2022 онд Засгийн 2014 оны 43 дугаар тогтоолын 2.1-2.4 дэх заалтын дагуу хэрэгжиж байсан бол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор шинэчлэгдснээр төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа 2023 оноос эхлэн хэрэгжиж байна. Журмын хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10. Төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа				Журмын орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааны хэрэгжилт
Хэрэгжүүлэх арга хэмжээ	хэзээ	хэн	ХААНА	
Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг хүргүүлэх	IV/01	Аймаг, Нийслэлийн Засаг даргад	БОАЖЯ	Аймгаас ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг боловсруулан хүргүүлдэг байна.

⁶ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

⁷ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоох	IV/01	БОАЖЯ	Аймаг, Нийслэлийн Засаг даргад	БОАЖЯ-аас ан, амьтан агнах дээд хэмжээг баталж ирүүлсэн. Бусад нөөцийн дээд хэмжээг тогтоож ирүүлээгүй.
Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум, дүүрэг тус бүрээр тогтоох	VII/01	Аймаг, нийслэлийн ИТХ	Сум, дүүрэг	Аймгийн ИТХ-аас сум тус бүрээр байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг батлаагүй.
Орлогын төлөвлөгөөг БНАТ-1 маягтын дагуу гаргах	VII/25	Сум, дүүргийн Засаг дарга нар	Аймаг, нийслэлийн БОАЖГ	Аймгийн хэмжээний 19 сумаас 2022 онд 5 сум нь БОАЖЯ-ны цахим системд орлогын төлөвлөгөөг шивж оруулсан бусад сум оруулаагүй. 2023 оноос бүх сумд оруулж хэвшсэн байна.
Орлогын төлөвлөгөөг БНАТ-3 маягтын дагуу боловсруулах	VII/25	Аймаг, нийслэлийн БОАЖГ	Байгаль орчныг хамгаалах, төсвийн зардлын мэдээллийн санд байршуулах	Аймгийн хэмжээний 19 сумаас 2022 онд 3 сум нь байгаль орчныг хамгаалах, төсвийн зардлын төлөвлөгөөг БОАЖЯ-ны цахим системд шивж оруулсан бусад сум оруулаагүй. 2023 оноос бүх сумд оруулж хэвшжээ.
Орлогын төлөвлөгөөг БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулах	VIII/01	Аймаг, нийслэлийн БОАЖГ	Аймаг, Нийслэлийн Засаг даргад	2022 онд орлогын төлөвлөгөөнд санал гаргаагүй. Харин 2023 оноос журмын дагуу хэрэгжихээр байна.

Б1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож байгаа хэдий ч ойн нөөц ашиглах эрхийн бичгийн зарцуулалтад тавих хяналт сул байна.

Аймгийн хэмжээнд 2021-2023 онд нийт 128 иргэнд элбэг ургамал бэлтгэх, 20393 иргэн, аж ахуй нэгжид ойн нөөц ашиглах, 208 иргэнд ан, амьтан агнах зөвшөөрлийг хууль журмын дагуу олгосон байна. Үүнийг он тус бүрээр хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-11. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийн судалгаа

Аймгийн нэр	Огноо	Ургамал		Ан		Ой	
		Олгосон зөвшөөрлийн		Олгосон зөвшөөрлийн		Олгосон зөвшөөрлийн	
		тоо	ашигласан хэмжээ	тоо	ашигласан хэмжээ	тоо	ашигласан хэмжээ
Архангай	2021 он	105	1707.3	84	1661	11049	77655.9
	2022 он	23	1704.3	124	1016	9324	82498
	2023 он	0	0	0	0	20	160
Нийт дүн		128	3411.6	208	2677	20393	160313.9

1.Хүснэгтээс харахад:

- ✓ 2021-2023 онд нийт 3411.6 кг элбэг ургамлын нөөцийг ашиглажээ.
- ✓ Олгосон нийт ангийн зөвшөөрлийн 84.6 хувь нь ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрөл байгаа бол 3.4 хувь нь шонхор шувуу гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтаны зөвшөөрөл байна.
- ✓ Ойн нөөц ашиглах зөвшөөрлийн 83.7 хувь нь ойн цэвэрлэгээний түлээ бэлтгэх зөвшөөрөл, 16.3 хувь нь ургаа мод огтолж, хэрэглээний мод, түлээ бэлтгэх зөвшөөрөл байна.

2. Харин ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн зарцуулалтад сумын Сум, дундын ойн ангиас тухай бүр хяналт тавьж, тооцоо нийлдэггүйгээс эрхийн бичгийн үлдэгдэл зөрүүтэй

зөрчил илэрлээ. Энэ нь Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 сарын 15-ны өдрийн А153 дугаар тушаалаар баталсан “Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам”-ын 5.7-т “Ойн анги, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, үлдэгдлийн тайланг улирал тутамд гаргаж, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Байгаль орчны газарт, Байгаль орчны газар нь тухайн сарын 15-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- ✓ Цэнхэр сум 2021-2022 оны мод бэлтгэх эрхийн бичгийн тооцоог сумын сум, дундын Ойн ангитай тооцоо нийлээгүйгээс үлдэгдэл 1.3 сая төгрөгөөр,
- ✓ Ихтамир сумын байгаль хамгаалагчид нь 2021-2022 оны мод бэлтгэх эрхийн бичгийн тооцоог сумын сум, дундын Ойн ангитай тооцоо нийлдэггүйгээс эрхийн бичгийн үлдэгдэл 26.7 сая төгрөгөөр,

Иймд ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн зарцуулалтад хяналт тавин байгаль хамгаалагч нартай тухай бүр үнэт цаасны тооцоог хийж хэвших албан шаардлагыг Цэнхэр, Ихтамир сумын Сум, дундын ойн ангийн дарга нарт хүргүүллээ.

3. Архангай аймгийн хэмжээнд 2021-2022 онд ус, рашааныг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан 6 сумын 6 иргэн, аж ахуй нэгж нь эрх бүхий байгууллагаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй байхад сумын Засаг даргатай гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулсан нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1⁸, 28.2⁹, 28.18¹⁰, 30.2.1¹¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаас ус, рашааныг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй иргэн, аж ахуй нэгжүүдийн ус ашиглуулах дүгнэлт гаргуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг Эрдэнэмандал, Хангай, Чулуут, Тариат, Төвшрүүлэх, Батцэнгэл сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэхгүй байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 556.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1582.4 сая төгрөг, 2022 онд 841.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2448.9 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-12. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Байгалийн нөөцийн төрөл	2021 он			2022 он		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү /давсан-, тасарсан+/-	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү /давсан-, тасарсан+/-
Ой, ойн дагалт баялаг	400.0	1,193.8	(793.8)	658.5	2,061.7	(1,403.2)
Байгалийн ургамал	2.0	1.6	0.4	1.5	1.7	(0.2)

⁸ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ энэ хуулийн 28.4-т заасан этгээдэд гаргана.

⁹ Ус ашиглах хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

¹⁰ Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

¹¹ рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын найрлага, чанарын үнэлгээний үзүүлэлтэд горимын ажиглалт хийлгэн баталгаажуулж, рашаан ашиглалтын бүртгэл хөтөлж, дүн мэдээг сав газрын захиргаанд хүргүүлэх;

Ус, рашаан	150.0	161.3	(11.3)	151.9	169.2	(17.3)
Ан, амьтан	4.0	225.7	(221.7)	30.0	216.3	(186.3)
дүн	556.0	1,582.4	(1,026.4)	841.9	2,448.9	(1,607.0)
Газрын төлбөр	80.0	243.3	(163.3)	267.6	272.9	(5.3)
нийт дүн	636.0	1,825.7	(1,189.7)	1,109.5	2,721.8	(1,612.3)

Хүснэгтээс харахад:

- ✓ Ой, ойн дагалт баялагийн төлбөрийн орлого 2021 онд 793.8 сая төгрөгөөр, 2022 онд 1403.2 сая төгрөгөөр давж биелсэн нь БОАЖС-ын 2022 оны А/379 дүгээ тушаалаар 5 суманд хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэж 1,697.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ Ан, амьтаны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл 2021 онд 221.7 сая төгрөгөөр, 2022 онд 186.3 сая төгрөгөөр давж биелсэн нь БОАЖС-аас тусгай зориулалтаар идлэг шонхор агнах барих зөвшөөрлийн дагуу 3 суманд нийт 9 шонхорыг гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргаж 260.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ Унд ахуйн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлого 2021-2022 онд 12.8-87.8 хувиар тасарсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д "Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд доод дээд төлбөрийн хязгаарыг тогтоосон" хэдий ч 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах зориулалтаар ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх"-өөр тусгасантай холбоотой байна.
- ✓ Газрын төлбөрийн орлого 2021 онд 163.3 сая төгрөгөөр, 2022 онд 5.3 сая төгрөгөөр давжээ.

Харин ойн нөөцийн төлбөрийн орлогыг дутуу, бөөн дүнгээр, он дамнуулан төвөлөрүүлдэг, анхан шатны баримтыг аудитад хамруулаагүй зэрэг зөрчил илэрсэн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.3-т "Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

- ✓ Ойн нөөцийн төлбөрийн орлогыг Чулуут сум 0.2 сая төгрөгөөр, Цахир сум 1.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэнд аудитаас төлбөрийн акт тогтоолоо.
- ✓ Өлзийт суманд ажлаас чөлөөгдсөн байгаль хамгаалагчтай холбоотой мод бэлтгэх эрхийн бичгийн тооцоо, нотлох баримтыг аудитад хамруулаагүй, ажлыг хүлээлцээгүй, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тайлант онд нь бүрэн төвлөрүүлээгүй, он дамжуулсан
- ✓ Хайрхан суманд орлогыг ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн зарцуулалттай тулгаж хянадаггүйгээс ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нь эрхийн бичгийн зарцуулалтаар тооцсноос 2021 онд 2.3 сая, 2022 онд 3.3 сая төгрөгөөр зөрсөн, төлбөр төлөгдсөн эрхийн бичгийг олгоогүй,
- ✓ Тариат сумын 2021-2023 оны ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг төлбөр төлөгч бүрээр бичээгүй, нэхэмжлэхийг нийт дүнгээр бичсэн, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухай бүрт нь төвлөрүүлээгүй, он дамжуулсан.
- ✓ Төвшрүүлэх суманд 2022 онд рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг амрагч бүрээс бүрэн төвлөрүүлээгүй, 2021 онд 1.1 сая төгрөг, 2022 онд 1.2 сая төгрөгийг төсвийн орлого хооронд гүйлгэн төвлөрүүлсэн

Иймд дээрх зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухай бүрт нь иргэн бүрээр нь нэхэмжлэх үүсгэж хоорондын тооцоог хийж, тухайн ондоо орлогыг төвлөрүүлж хэвших албан шаардлагыг Хайрхан, Тариат, Төвшрүүлэх, Өлзийт сумын Засаг дарга нарт хүргүүллээ.

Б2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 28.7 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна

Б.2.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлбөрийн орлогын 44.1 хувь нь менежмент төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 зүйлийн 16.2.2¹²-т заасны дагуу аймгийн ИТХТ-ийн 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 23 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2021 онд 339.5 сая төгрөгийн 17 арга хэмжээг, 2022 онд 574.7 сая төгрөгийн 10 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр баталжээ. Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр тогтоолын тодотгосон төсвөөр байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2022 онд 574.6 сая төгрөгийн 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн Цэнхэр, Жаргалант, Булган, Ихтамир, Цахир сумдууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2021 онд 436.2 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг, 2022 онд 591.6 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар баталжээ.

Архангай аймаг болон 5 сумын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг дундажаар 2021 онд 45.4 хувиар, 2022 онд 78.2 хувиар, 2023 онд 49.3 хувиар дутуу төлөвлөж баталсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалттай нийцэхгүй байна.

¹² Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

График 2. Аймаг, сумдын 2021-2023 оны байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг хуулийн хэрэгжилтийн хувиар харуулбал:



Графикаас харахад аймаг, сумдын хэмжээнд ан амьтан, ус рашаан, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлд хуульд заасан хувь хэмжээгээр тооцож байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдлийг бий болгож болзошгүй байна.

Аудитаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг баримталж төлөвлөх зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

Байгалийн нөөц бүрээр менежмент төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн эсэхийг нөөцийн төрөл бүрээр харуулбал:

Ойн тухай хуулийн дагуу 2021-2023 оны байдлаар аймгийн ойн нөөцийн хэмжээг тогтоох, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх зэрэг асуудлаар ойн менежмент төлөвлөгөөг холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна.

Харин 2021 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөс аймгийн БОАЖГ-ын захиалгаар 9.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Архангай аймгийн байгаль орчныг хамгаалах, ойн сан бүхий сумдын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах” ажлыг “Агрофорест” ХХК гүйцэтгэж, 2021 оны 12 сард хүлээлгэн өгчээ.

Аймгийн хэмжээнд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын жагсаалтад 2021 онд 27, 2022 онд 16, 2023 онд 13 нийт 56 арга хэмжээ буюу 44.1 хувь нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээнүүд байна.

Хүснэгт-13. БОХНСАХ нь менежмент төлөвлөгөөтэй уялдсан байдал

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Байгалийн нөөцийн төрөл					
	Ойн нөөц			Ан амьтны нөөц		
	2021	2022	2023	2021	2022	2023
Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	0	11	38	3	5	14
Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй	27	16	13	0	0	0
НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	27	27	51	3	5	14

/Эх сурвалж: БНАТ-ын нэгдсэн судалгааны Б2.1 дахь судалгаа/

Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө, ойн сан бүхий сумдын ойн менежмент төлөвлөгөөнд тусгагдсан 30 арга хэмжээнд 268.3 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулжээ.

Хүснэгт-14. Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан БОХНСАХ-ний зардлын дэлгэрэнгүй
/сая төгрөг/

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	Байгалийн нөөцийн төрөл						ДҮН
	Ойн нөөц			Ан амьтны нөөц			
	2021	2022	2023	2021	2022	2023	
Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	-	11	38	3	5	14	71
Үүнээс зарцуулагдсан	-	11	12	3	4	-	30
Зарцуулсан мөнгөн дүн	-	137.64	93.84	15.92	20.94	-	268.34
Менежментийн төлөвлөгөөнд тусгаадаагүй	27	16	13	-	-	-	56
үүнээс зарцуулагдсан	16	11	4	-	-	-	31
Зарцуулсан мөнгөн дүн	116.82	248.61	17.80	-	-	-	383.22

Эх сурвалж: БНАТ-ын нэгдсэн судалгааны Б2.2 дахь судалгаа/

Хүснэгтээс харахад ой, ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй 31 арга хэмжээнд 383.2 сая төгрөгийг зарцуулсан нь дараах шалтгаанаас үүдэлтэй байна. Үүнд:

- ✓ Архангай аймаг, сумдын ойн менежментийн төлөвлөгөө 2021 онд батлагдаагүй.
- ✓ Цэнхэр сум нь сумын ойн менежмент төлөвлөгөөгөө 2022, 2023 онд боловсруулж, батлуулаагүйтэй холбоотой байна.

Архангай аймгийн хэмжээнд 2021-2023 оны байдлаар ус рашаан, ургамлын нөөцийн менежмент төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна.

2021 онд газар, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаагүй байна.

Хүснэгт-15. БНАТ-ын орлогын төлөвлөлт /2021 он/

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Он	Орлогын батлагдсан төлөвлөгөө	Хуульд заасан хувь	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ		Зөрүү
				Төлөвлөвөл зохих дүн	Төлөвлөсөн дүн	
Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	2021	2,460.20	15.00	369.03	-	(369.03)
Газрын төлбөрийн орлого	2021	80.00	15.00	12.00	-	(12.00)
ДҮН						(381.03)

Архангай аймгийн хэмжээнд 2022 онд ой, ан амьтан, газар, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг 77.7 хувиар буюу 723.8 сая төгрөгөөр дутуу төлөвлөжээ.

Хүснэгт-16. БНАТ-ын орлогын төлөвлөлт /2022 он/

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Он	Орлогын батлагдсан төлөвлөгөө	Хуульд заасан хувь	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ		Зөрүү
				Төлөвлөвөл зохих дүн	Төлөвлөсөн дүн	
						Хувь

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	2022	1,452.30	85.00	1,234.46	669.70	(564.76)	(45.75)
Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	2022	251.70	50.00	125.85	18.80	(107.05)	(85.06)
Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	2022	1.50	15.00	0.23	-	(0.23)	(100.00)
Газрын төлбөрийн орлого	2022	430.90	15.00	64.64	12.90	(51.74)	(80.04)
ДҮН						(723.78)	(77.71)

2023 онд ой, ан амьтан, газар, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаас 41.1 хувиар буюу 347.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, аймгийн усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарцуулах арга хэмжээг аймгийн ИТХ-аар дэлгэрэнгүй жагсаалтаар батлуулаагүй байна.

Хүснэгт-17. БНАТ-ын орлогын төлөвлөлт /2023 он/

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Он	Орлогын батлагдсан төлөвлөгөө	Хуульд заасан хувь	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ		Зөрүү	
				Төлөвлөвөл зохих дүн	Төлөвлөсөн дүн		Хувь
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	2023	1,763.20	85.00	1,498.72	1,234.46	(264.26)	(17.63)
Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	2023	196.30	50.00	98.15	27.00	(71.15)	(72.49)
Ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	2023	1.00	15.00	0.18	0.10	(0.08)	(44.44)
Газрын төлбөрийн орлого	2023	277.90	15.00	41.69	29.30	(12.39)	(29.72)
ДҮН						(347.88)	(41.07)

2023 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн доод хувь хэмжээг Ихтамир, Цэнхэр, Булган, Жаргалант, Цахир, Өндөр-Улаан, Тариат, Хайрхан, Өгийнуур сум хуульд зааснаас дутуу төлөвлөсөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Б.2.2. 2021-2023 онуудад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 7.8-39.8 хувийг зориулалт бус зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2021 онд 775.7 сая төгрөгийг 39 арга хэмжээнд, 2022 онд 1,166.3 сая төгрөгийг 48 арга хэмжээнд зарцуулахаар батлуулжээ. Гүйцэтгэлээр 2021 онд 498.9 сая төгрөгийг 38 арга хэмжээнд, 2022 онд 1,003.3 сая төгрөгийг 45 арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

Хүснэгт-18. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2021, 2022 оны зардлын төлөвлөлт, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Сумын нэр	Он	2021-2022 он			
				Мөнгөн дүн		Зориулалт бус

			Баталсан арга хэмжээний тоо		Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Аймаг	2021	17	339.50	16	192.50	5	78.40
		2022	18	574.70	18	486.60	4	174.70
2	Цэнхэр	2021	12	90.50	12	80.60	6	45.20
		2022	6	238.00	5	190.10	2	109.90
3	Жаргалант	2021	1	105.20	1	23.50	1	23.50
4	Булган	2021	7	52.20	7	48.40	1	8.10
		2022	15	226.00	15	226.00	2	80.00
5	Цахир	2022	8	101.50	6	84.30	4	70.30
6	Ихтамир	2021	2	188.30	2	153.90	2	153.90
		2022	1	26.10	1	16.30	1	16.30
Нийт дүн		2021	39	775.7	38	498.9	15	309.1
		2022	48	1166.3	45	1003.3	13	451.2

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2021 онд 15 арга хэмжээнд 39.8 хувь буюу 309.1 сая төгрөгийн, 2022 онд 13 арга хэмжээнд 451.2 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹³, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.7¹⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Дүрслэл-2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалттай холбоотой 2021 онд 309.1 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалтыг дүрслэлээр харуулбал:



2021 онд барилга байгууламжид 67.1% буюу 207.5 сая, тээвэр шатахууны зардалд 6.6% буюу 20.3 сая төгрөг, их засварын ажилд 2.6% буюу 8.1 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхэд 23.7% буюу 73.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Дүрслэл-3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалттай холбоотой 2022 онд 451.2 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалтыг дүрслэлээр харуулбал:

¹³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹⁴ Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно



2022 онд барилга байгууламжид 13.5 хувь буюу 59.8 сая, их засварт 1.8 хувь буюу 8.0 сая, хөрөнгө бэлтгэхэд 63.5 хувь буюу 286.4 сая, сургалтын зардалд 3.3 хувь буюу 15.0 сая төгрөг, аялал жуулчлалын арга хэмжээнд 18.2 хувь буюу 82.0 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.

2023 онд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу аймаг болон 19 сумд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 1,720.2 сая төгрөгийн 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар батлуулжээ.

Хүснэгт-19. Аймаг, сумдын 2023 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсөв, гүйцэтгэл

Сумын нэр	ИТХ-аар баталсан арга хэмжээ		Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Зориулалт бус зарцуулалт	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Ихтамир	6	265.83	3	61.98	1	16.00
Чулуут	8	13.98	1	5.00		
Хангай	5	5.39	-			
Тариат	4	327.73	3	16.60		
Өндөр-улаан	2	18.49	1	3.00	1	3.00
Эрдэнэмандал	5	11.17	1	1.68		
Жаргалант	15	317.86	6	41.00	3	33.20
Цэцэрлэг	3	7.16	1	1.79		
Хайрхан	2	8.80	-	-		
Батцэнгэл	6	40.09	1	4.42		
Өлзийт	2	2.16	-	-		
Өгийнуур	3	33.83	-	-		
Хашаат			-	-		
Хотонт	5	12.80	-	-		
Цэнхэр	16	302.47	6	79.86	5	73.86
Төвшрүүлэх	7	10.22	-	-		
Булган	15	232.06	5	29.60	1	7.80
Цахир	4	30.43	1	5.00		
Эрдэнэбулган	1	3.30	-	-		
Аймаг	1	76.45	-	-		
Нийт дүн	110	1,720.2	29	249.9	11	133.8

Аймгийн хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын байдлаар 249.9 сая төгрөгийн 29 арга хэмжээг хэрэгжүүлсэн ч журмын заалтад хамааралгүй 11 арга хэмжээнд 133.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹⁵, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.7¹⁶ дахь заалттай

¹⁵ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹⁶ Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно

нийцэхгүй байна.

Иймд аудитаас Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ыг мөрдөж, зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлагыг Ихтамир, Өндөр-Улаан, Жаргалант, Цэнхэр, Булган сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

Дүрслэл-4. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний төсвөөс 2023 онд зориулалт бус зарцуулсныг дүрслэлээр харуулбал:



Байгаль хамгаалагч нарт ажлын хувцас, хэрэглэл худалдан авахад 11.9 хувь буюу 16 сая, машин, тоног төхөөрөмж худалдан авахад 64.9 хувь буюу 87.0 сая, зам засвар, ариун цэврийн байгууламжийн ажилд 8.9 хувь буюу 12.0 сая, хог зайлуулах, сэг зэм устгахад 14 хувь буюу 18.8 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулжээ.

БҮЛЭГ В. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА


В.1. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, цахим бүртгэлийн системийн хуулийн хэрэгжилт 22.0 хувьтай байна

В1.1 Архангай аймгийн хэмжээнд мэдээллийн сан бүрдүүлэх цахим бүртгэлийн системийн хуулийн хэрэгжилт 22.0 хувьтай, ил тод байдал хангагдаагүй байна.

Сумын нэр	eic.mn/finance/ цахим систем	Аудитаар	Зөрүү	Хувь
БНАТ-ын орлогын төлөвлөгөө /сая.төг/	728.10	1,109.60	(381.50)	65.62
БНАТ-ын орлогын гүйцэтгэл /сая.төг/	230.50	2,722.40	(2,491.90)	8.47
Давсан орлого /сая.төг/	170.10	1,190.60	(1,020.50)	14.29
БОХНСАХ-нд зарцуулах зардлын төлөвлөгөө /сая.төг/	117.90	1,166.30	(1,048.40)	10.11
БОХНСАХ-нд зарцуулах зардлын гүйцэтгэл /сая.төг/	116.00	1,003.30	(887.30)	11.56
ДҮН				22.01

Архангай аймаг нь 2022 оноос eic.mn/finance цахим бүртгэлийн системд нэвтэрсэн бөгөөдхуулийн хэрэгжилт 22.0 хувьтай байна.

2022 онд eic.mn/finance цахим системд БНАТ-ын орлогын төлөвлөгөөний мэдээг Архангай аймаг болон сумдын 10.6 хувь нь, орлогын гүйцэтгэлийн мэдээг 91.5 хувь нь тус тус байршуулаагүй байна. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөний мэдээг 85.7 хувь нь, зарцуулалтын гүйцэтгэлийн мэдээг 88.4 хувь нь мэдээлээгүй байна.



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалтын мэдээллийн сан бүрдүүлэлтийн eic.mn/finance цахим систем иргэд олон нийтэд ил тод нээлттэй биш, зөвхөн байгаль орчны улсын байцаагч нар мэдээлэл оруулах эрхийн хүрээнд ашиглагдаж байна.

В1.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-т Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар бүрэн эрхийг тусгажээ.

Мөн Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.8-д “ Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана” гэж заасан.

Энэ хүрээнд БОАЖС нь аймгийн Засаг даргатай, аймгийн Засаг дарга нь сумын Засаг дарга нартай гэрээ байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүгнэж ажилласан байна.

Орон нутагт байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцдоггүй, аймгийн хэмжээний нэгтгэсэн тайлан мэдээ, судалгааг гаргаж дүн шинжилгээ хийж үр дүнг тооцоогүй, хяналт сул байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Засгийн 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журамтай бүрэн нийцэхгүй байна.

Аудитаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомж, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан мэдээ,

судалгааг бодлогын хэмжээнд нэгтгэн гаргаж үр дүнг тооцож хэвших, хуулийн хэрэгжилтэд тавих шат шатны хяналтыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна

В2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын хэрэгжилтэд улсын хэмжээнд хяналт, үнэлгээ хийжээ. Энэ хяналт үнэлгээгээр аймгийн БОАЖГ-т зөвлөмж, дүгнэлт өгөөгүй байна. */Эх сурвалж: аймгийн БОАЖГ-ын 2023.06.19-ны өдрийн 191 дугаар албан бичиг/*

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн хэмжээнд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2021, 2022 оны гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй байна. */Эх сурвалж: аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2023.05.18-ны өдрийн 72 дугаар албан бичгийг үндэслэв/*

В2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2021 оноос 2023 оны 5 дугаар сарыг хүртэлх хугацаанд аймаг, сумын ИТХ-аас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж ажиллаагүй байна. Энэ нь Байгаль орчны тухай хуулийн 16.1¹⁷-т, 17.1¹⁸, дэх заалттай нийцэхгүй байна. */Эх сурвалж: аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 52 тоот албан бичгийг үндэслэв/*

Байгаль орчны тухай хуулийн дагуу орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймаг, сумын ИТХ-д хүргүүллээ.

¹⁷ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

¹⁸ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн актын зарим заалтууд хоорондоо уялдаагүй байна
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 83.7 хувийг хууль тогтоомжийн дагуу төлөвлөөгүй байна
- ✓ Эрх бүхий байгууллагаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүй байна

Аудитын дүн: Аудитаар нийт 748.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 746.9 сая төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 10 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүллээ.

УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Төсвийн тухай хууль болон МУЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ын холбогдох заалтын хүрээнд Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг уламжилж байна.

АУДИТААС ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн ИТХ-ын даргад:

- ✓ Ахуйн зориулалтаар агнах ан, амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр батлан Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын 2.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн ИТХ-аас хяналт тавих ажлыг зохион байгуулж үр дүнг тооцох

Аймгийн Засаг даргад:

- ✓ Ойн тухай хуулийн дагуу аймгийн хэмжээний ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, арга хэмжээ авч ажиллах
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах зардлын хуульд заасан хувь хэмжээнээс бууруулахгүйгээр тооцож төлөвлөх
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан мэдээ, судалгааг бодлогын хэмжээнд нэгтгэн гаргаж үр дүнг тооцож хэвших, хуулийн хэрэгжилтийг хянах арга хэмжээг зохион байгуулах
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэж, арга хэмжээ тус бүрээр аймгийн ИТХ-аар батлуулж хэвших

Аймгийн БОАЖГ-ын даргад:

- ✓ Ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх зорилготой 96 нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийн менежмент төлөвлөгөөг хянаж батлах, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргад:

- ✓ Сумын Засаг дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ хийж үнэлж дүгнэсэн баримт материалыг холбогдох хуулийн дагуу архивын нэгж үүсгэж хадгалах

Сумдын Засаг дарга нарт:

- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хуульд заасан хувь хэмжээг бууруулахгүйгээр тооцож төлөвлөх
- ✓ Төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй урсгал шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлэхгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

-----oOo-----

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлтэй танилцаад саналгүй гэсэн хариу албан бичгийг ирүүлсэн.



**АРХАНГАЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

1 дүгээр баг, Эрдэнэбулган сум,
Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3223,
Цахим шуудан: arkhangaiboaig01@gmail.com

2023.06.19 № 193

танай _____-ны № _____-т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийсэн ГАА-2023/30-ШТА-НА код бүхий аудитын тайлангийн дүгнэлтэд тусгах саналгүй болно.



ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТНАЙРАМДАЛ

Аудитор Т. Цог-Арвин
Танилцуулсан
2023.06.19

652304342

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/28

Эрдэнэбулган сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын тавдугаар хавсралтын 1.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн удирдамжийн дагуу "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-нд хийсэн нийцлийн аудит (ГАА-2023/30-ШТА-НА)-ын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай

3. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, БОАЖГ-т хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Нийцлийн аудитын багийн ахлах аудитор (П.Цэцэгдулам), аудитор (Г.Цог-Эрдэнэ) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Төргүүлэх
аудиторын 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 48 дугаар
тушаалын хавсралт

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт" -д хийсэн
нийцлийн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн жагсаалт

№	Хүргүүлсэн шийдвэрийн				Огноо	Хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн	Тоо	Шийдвэр		Байгууллагын	Овог нэр
1	Зөвлөмж хүргүүлэх тухай	76,454,600.00	4	Зөвлөмж өгөх	2023.06.19	Архангай аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
2	Зөвлөмж хүргүүлэх тухай	-	1	Зөвлөмж өгөх	2023.06.19	БОАЖГ-ын дарга	Ч.Батнайрамдал
3	Зөвлөмж хүргүүлэх тухай	-	1	Зөвлөмж өгөх	2023.06.19	Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ын дарга	Б.Лхагвасүрэн
4	Зөвлөмж хүргүүлэх тухай	-	2	Зөвлөмж өгөх	2023.06.19	Сумдын Засаг дарга нарт	Засаг дарга
5	Зөвлөмж хүргүүлэх тухай	-	2	Зөвлөмж өгөх	2023.06.19	Аймгийн ИТХ-ын дарга	Б.Батжаргал
6	Хариуцлага тооцуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.06.19 367/A0370219	Архангай аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
7	Зөрчил арилгуулах тухай	-	4	Албан шаардлага	2023.06.19 366/A0370216	БОАЖГ-ын дарга	Ч.Батнайрамдал
8	Зөрчил арилгуулах тухай	222,587,200.00	2	Албан шаардлага	2023.06.19 368/A0370219	Цэнхэр сумын Засаг дарга	Д.Галхүү
9	Зөрчил арилгуулах тухай	95,890,000.00	2	Албан шаардлага	2023.06.19 369/A0370219	Булган сумын Засаг дарга	Ц.Төрхүү
10	Зөрчил арилгуулах тухай	186,189,000.00	2	Албан шаардлага	2023.06.19 370/A0370219	Ихтамир сумын Засаг дарга	Б.Цэвээндорж
11	Зөрчил арилгуулах тухай	56,650,000.00	2	Албан шаардлага	2023.06.19 371/A0370219	Жаргалант сумын Засаг дарга	Н.Алтанхуяг
12	Зөрчил арилгуулах тухай	70,315,664.00	1	Албан шаардлага	2023.06.19 372/A0370219	Цахир сумын Засаг дарга	Д.Галбаатар
13	Зөрчил арилгуулах тухай	1,269,755.00	1	Албан шаардлага	2023.06.19 373/A0370219	Цэнхэр сумын Сум дундын ойн	Ц.Буянжаргал
14	Зөрчил арилгуулах тухай	26,695,633.00	1	Албан шаардлага	2023.06.19 365/A0370219	Ихтамир сумын Сум дундын ойн	Т.Мөнх-Эрдэнэ
15	Зөрчил арилгуулах тухай	3,000,000.00	1	Албан шаардлага	2023.06.19 379/A0370220	Өндөр-Улаан сумын Засаг дарга	Ю.Баасанжаргал
16	Зөрчил арилгуулах тухай	5,606,240.00	1	Албан шаардлага	2023.06.19 380/A0370220	Хайрхан сумын Засаг дарга	Л.Чойжжанцан
17	Зөрчил арилгуулах тухай	297,859.00	1	Албан шаардлага	2023.06.19 381/A0370220	Өлзийт сумын Засаг дарга	Г.Баттулга
18	Зөрчил арилгуулах тухай	2,337,800.00	2	Албан шаардлага	2023.06.19 382/A0370220	Төвшрүүлэх сумын Засаг дарга	Б.Бямбаа
19	Зөрчил арилгуулах тухай	-	2	Албан шаардлага	2023.06.19 378/A0370220	Тариат сумын Засаг дарга	Б.Буяннэмэх
20	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.06.19 374/A0360217	Эрдэнэмандал сумын Засаг дарга	Н.Лхагвадорж
21	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.06.19 375/A0360217	Чулуут сумын Засаг дарга	Б.Туул
22	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.06.19 376/A0360217	Хангай сумын Засаг дарга	Д.Өрнөхбаяр
23	Зөрчил арилгуулах тухай	-	1	Албан шаардлага	2023.06.19 377/A0370217	Батцэнгэл сумын Засаг дарга	Ц.Зоригтхүү
24	Төлбөр барагдуулах тухай	1,074,526.00	1	Төлбөрийн акт	2023.06.19 75/A0360217	Цахир сумын Засаг дарга	Д.Галбаатар
25	Төлбөр барагдуулах тухай	218,033.00	1	Төлбөрийн акт	2023.06.19 76/A0360217	Чулуут сумын Засаг дарга	Б.Туул
	Төлбөрийн актын дүн	1,292,559.00	2				
	Албан шаардлагын дүн	670,839,151.00	27				
	Зөвлөмжийн дүн	76,454,600.00	10				
	НИЙТ ДҮН	748,586,310.00	39				